



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/535

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3 дахь заалт, Залуучуудын хөгжлийн үндэсний хөтөлбөрийн 3, 5.1, 5.1.4, 5.1.11, 5.11, 5.1.13, 5.2.13 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын төрийн бус байгууллагуудтай хамтран Дарви, Булган, Ховд, Жаргалант сумдад “Залуучуудын хөгжлийн суурь судалгаа, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулах арга хэмжээний зардалд 15000000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх сумдад зохион байгуулах арга хэмжээний зардал 15000000 төгрөг /арван таван сая/-ийг аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний 5.25 дахь заалтын “Залуучуудын хөгжлийг дэмжих /судалгаа/” зардлаас тооцож, олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

